



6. ЭСЭЭ БИЧИХ ДАСГАЛ ХИЙЦГЭЭЕ...

ЭСЭЭ БИЧИХ АРГАЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Ц. Оюун,

МУБИС-ийн Монгол судлалын сургууль

Summary:

From this article you got an information about how to write an essay properly and using widely and definition of an essay. Essay is one of the important appliances of teaching. In this case let's use an essay widely in our teaching and researeh work.

Түлхүүр санаа:

Эсээг зөвхөн үнэлж дүгнэх хэрэглүүр болгох бус, өргөн хүрээгээр ойлгож, түүний бусад олон нээлттэй боломжийг эрж хайн бүрэн дүүрэн ашиглах, эсээний хэвшмэл бүтцийг баяжуулан, хувилбартай авч үзэх нь эдүгээ тулгамдсан, жижиг гэхгүй асуудлын нэг болжээ. Энэ сэдвээр ажилладаг багш, судлаач, аргазүйчдэд зарим талаар санаа өгөх үүднээс эл өгүүллийг бичиж, дурдсан чиглэлүүдээр авч үзэв.

Key words:

One of the important problems of writing an essay is that we mustn't consider it as an assessment appliience. It's thought widely finding other many opened sides of it and use it completely enriching it in structure and take it in verston. I wrote this article for the teachers, researchers and methodologists who work on this problem to get an idia about essay.

Эсээний тухай ойлголт

Эсээ гэдэг үгийг “оролдлого, сорьц найруулал” гэсэн утгатай Францын “essai” гэдэг үг ба “жинлэх” гэсэн утгатай “exagium” гэдэг латин үгнээс гаралтай хэмээн үздэг байна. Эсээ гэх үгийг Мюллерийн “English-russian dictionary” толь (Moscow, 1991)-д “essay”, очерк- найруулал, “ессе” попытка – оролдлого, Хангины Гомбожавын “A Concise English-Mongolian Dictionary” толь (Хөх хот, 1984)-д “найруулал”, Д.Алтангэрэлийн “Англи монгол” тольд “нийтлэл”, Susan Maingayн “longman active study dictionary of English” тольд “тодорхой сэдвээр бичсэн богино хэмжээний найруулал” гэх мэтээр тус тус тайлбарласан байна.

Эсээ нь нэгэн бүхэллэг санааг илэрхийлсэн, бүтээлч, хийсвэр сэтгэлгээний гарц бөгөөд аль нэг юм үзэгдлийн талаар гүн ухаан, нийгэм түүх, утгазохиол, судлал шүүмжлэлийн үүднээс төсөөлөн, ухаан санаандаа бясалгасан хүүрнэх, тайлбарлах найруулбар бүхий бичмэл үр дүн мөн. Эсээг боловсролын салбарт эсээ, эссе, исээ гэх мэтээр янз бүрээр бичдэг. Л.Түдэв гуай “Исэж жигдэрсэн айраг лугаа адилшаан, бясалгаж иссэн бодлын энэхэн хэсгийг исээ хэмээн монгол үсгээр тэмдэглэлээ хэмээсэн нь ч бий. Ямартай ч гэсэн, анх энэ үг гадаадад үүсэж буй болсон нь essai бөгөөд тэр дуудлагаар нь монголчилж нэршсэн эсээ гэдэг үгээр нэгэнт бичиж хэвшжээ.

Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх Хөтөлбөрийн хүрээнд судлаачид эсээг нэлээд тодорхой авч үзсэн бөгөөд “Эсээ гэдэг бол аль нэг асуудлаар бусад хэнийхтэй ч төсгүй, өөрийн үзэл бодлоор бичсэн голцуу богино хэлбэрийн хүүрнэлт бичлэг” хэмээн нэгэн өгүүлэлдээ тэмдэглэсэн нь нэлээд оносон тодорхойлолт бололтой. Эл өгүүлэлдээ ч тэдний авч үзсэн аргазүйг зарим хэсэгт эш үндэс болголоо:

Эсээг бид, оюутан, сурагчдын мэдлэгийн төвшин тогтоох бүтээлч бичлэгийн хэлбэр болгох ганц зориулалтаар ашигласаар ирсэн бол эдүгээ эл уламжлалаа баяжуулан өөр олон зориулалтаар бичүүлж хэрэглэх хэрэгтэй болжээ. Тухайлбал эсээг:

- Хувь багш, оюутны нийгэмшил, төлөвшил, тэдний хандлага, санал санаачлагыг судлан сургуулийн болон тэнхим хамт олны ажлыг төлөвлөх,
- Тодорхой асуудлаар нэгдмэл нэгэн ойлголтод хүрэх судалгааны танадалтад хэрэглэх,
- Маргаантай асуудлыг ухаалгаар шийдэх гарц олоход цугларсан үнэт санаануудаар баяжуулан авч үзэх,
- Багш, судлаачдын судалгаа шинжилгээний ажил, онолын үзэл баримтлал, байр суурийг нь тодотгох
- Маркетинг, менежментийн бодлого боловсруулах хийгээд ажлын стратеги төлөвлөлтөд санал тусгах зэрэг янз бүрийн зорилгоор, аль нэгийг сонгон авч эсээ бичүүлж болох байна.

Тэрчлэн хувь хүн ч өөрийн бодол санааг эсээгээр хэлбэржүүлж бүтээлийн сандаа хадгалахыг үгүйсгэхгүй. Эсээний хаан Мишель де Монтень эсээний бүтээлээрээ дэлхийд ноёрхлоо тогтоосон туршлага ч бий юм. Мөн эрдэмтэн, зохиолч Л.Түдэв, эрдэмтэн Д.Баттогтох нарын болон нэрт улс төрчид, эдийн засагчдын бичсэн эсээ-бүтээл монгол түмнийхээ гар дээр олон арваараа очоод буйг энд дурдахад таатай байна.

Эсээний бүтэц

Эсээг бид эхлэл, үндсэн хэсэг, төгсгөл хэсэг гэсэн уламжлалт бүтцээрээ өдгөөг хүртэл бичсээр, бичүүлсээр ирсэн. Эсээ бичих олон хэв маяг бий бөгөөд тэдгээрийн дотроос Алис Ошима, Анн Хог нарын боловсруулсан бүтцээр бичвэл дараах хэв маягтай байж болно:

1. Танилцуулах хэсэг:
 - Ерөнхий мэдээлэл
 - Сэдвийн мэдээлэл
2. Үндсэн хэсэг:
 - Толгой өгүүлбэр
 - Дэмжих өгүүлбэр
 - Толгой өгүүлбэр
 - Дэмжих өгүүлбэр
 - Толгой өгүүлбэр
 - Дэмжих өгүүлбэр...
3. Дүгнэлт хэсэг:
 - Дүгнэсэн өгүүлбэр
 - Эсээ бичигчийн өөрийн бодол гэсэн бүтэцтэй юм.

Хэсэг тус бүрийн онцлог:

1.Танилцуулах хэсэг

Танилцуулах хэсэг үндсэндээ уншигчдад эсээний тухай өмнөтгөл мэт угтал ойлголт өгөх үүрэгтэй юм. Дээр бид, эсээний танилцуулах хэсэг дотроо ерөнхий мэдээлэл ба сэдвийн мэдээлэл гэсэн хоёр бүтэцтэй хэмээн үзсэн бөгөөд тус бүрийн тухайд товч авч үзвэл:

Ерөнхий мэдээлэлд, бичих эсээнийхээ тухай суурь ойлголт бүхий товч, нэгээс хоёр өгүүлбэрт багтсан мэдээллийг уншигчид өгнө. Ерөнхий мэдээлэл уншигчийн сонирхол татахуйц байвал уншигч эсээг үргэлжлүүлэн унших нь эргэлзээгүй. Иймд энэ хэсэг хэр ач холбогдолтой болох нь ойлгомжтой. Үлгэрлэвэл, “Мөнгөний тухай эргэцүүлэл” сэдвээр эсээ бичиж байна гэж бодъё. Танилцуулах хэсгийн ерөнхий мэдээллийн хэсэгт:” Бид мөнгөний тухай дор бүрдээ л өөрийн гэсэн нэг ойлголттой байдаг. Тэр ч байтугай хуульчид, эрхзүйчид, санхүүчид, эдийн засагчид хуулинд заасан нэг ойлголттой байлаа ч өөрийн нь хувь үзэл гэхэд бас арай нэг өөр бодолтой байхыг үгүйсгэх аргагүй. Иймд бид энэ эсээгээрээ мөнгө тойрсон асуудлаар өөрийн гэсэн байр сууриа Уншигч тантай хуваалцъя уу хэмээсэн бүлгээ” гэх жишээтэй өлгөц хэсгийг эсээ бичигч бичих юм.

Сэдвийн мэдээлэлд, бичих эсээнийхээ тулгуур санаа буюу цөм агуулгыг товч танилцуулна. Өөрөөр хэлвэл эсээнд авч үзэх гол ба дэд санаануудыг бүлэглэн тоймлож бичих ба энэ нь эсээний бүтэц зохион байгуулалтын тухай мэдээллийг уншигчид өгч байна гэсэн үг. Үлгэрлэвэл, “Бид энэ эсээндээ мөнгөний үнэ цэн, мөн чанар, мөнгөний тухай уламжлалт ба орчин үеийн хэвшмэл үзэл, хүмүүсийн мөнгөнд хандах хандлага, мөнгөтэй харьцах соёл, хэрэглээний тухай зарим асуудлыг хөндөх бодолтой байна” гэх жишээтэйгээр ерөнхий мэдээлэлд өлгөсөн санаагаа ахиулж болох юм. Эсээний танилцуулга хэсэг ийнхүү ерөнхийгээс тодорхойд дэлгэрсэн, пирамид буюу трапец дизайнтай байна.

2. Үндсэн хэсэг

Эсээний үндсэн хэсэг мэдээж, толгой өгүүлбэр ба дэмжих өгүүлбэрүүдээс бүрдэх хэд хэдэн дэд хэсгийг багтаасан нэгэн бүхэллэг байх учиртай. Дэд хэсгүүд сэдвийн мэдээлэлд дурдсан бүтцийг хадгалахын зэрэгцээ өмнөх дэд хэсгээ дэмжсэн, арын дэд хэсгийн угтал болсон мэт гинжин бүтэцтэй байвал зохино. Толгой өгүүлбэр гэдэг нь үндсэн хэсгийн нэгэн цул санаа бөгөөд түүнийг баталж нотолсон, тодотгосон шинжтэй жишээ баримт, дагуул өгүүлбэрүүдийг дэмжих өгүүлбэрүүд хэмээн үзнэ. Жишээ нь, үндсэн ба дэд хэсэгт, эсээ бичигч мөнгөний тухай өөрийн үзэл бодлын тухай, тэр тухай мэдээллийн бусад эх үүсвэрт хэрхэн тайлбарласан байдаг тухай түлхүүр, тулгуур санаануудаа эмх цэгцтэй өгүүлж дэмжих өгүүлбэрүүдээрээ баталгаажуулна. Эсээнд өгүүлж байгаа санаа бүхэн бүтээлч, шинэ содон мэдээлэл агуулж байхыг мартаж үл болно.

3. Дүгнэлт хэсэг

Эсээний дүгнэлт хэсэг уншигчид төрсөн санааны бүтээлч, бүтээлч бус хандлага, латерал, вертикал сэтгэлгээнд нөлөөлөх нь бий. Дүгнэлт хэсэг дараах үүрэгтэй юм:

- Юуны өмнө эсээ төгсөх гэж байгаа тул уншигч санаагаа төвлөрүүлэн зангидаж өөрийн гэсэн байр сууриа цэгнэн үзэх, эсээнд дэвшүүлсэн санааг үргэлжлүүлэн бодох, дахин нэг санахад туслах боломж олгоно.
- Мөн эсээний агуулгын талаар нэгдмэл дүр зургийг гаргаж, тоймолсон сэтгэгдэлд хүргэнэ.
- Эсээний сэдвээрх шинэ санааг уншигчид үлдээнэ.

Дүгнэлт хэсгийг үндсэнд нь:

- Дүгнэсэн буюу төгсгөсөн
- Зохиогчийн бодол гэсэн хоёр хэсгээс бүрддэг гэж үзэж болно. Дүгнэсэн буюу төгсгөсөн өгүүлбэр нь танилцуулга хэсгийн эхлэлтэй адил ерөнхий мэдээлэл агуулахаас гадна уншигчдад сэдвийн мэдээллийг эргэн сануулах учиртай.

Эсээ бичих дэс

Эсээг бэлтгэлтэй ба бэлтгэлгүй шууд бичүүлж болно. Харин оюутнаар бичүүлэх эсээг бэлтгэлтэй бичүүлвэл үр дүнтэй байх болно. Эсээг сургалтын ба санал боловсруулах, судалгаа танадалтын хэмээн ангилж болох ба сургалтын зориулалт бүхий эсээг оюутнаар бичүүлэх бол дараах дэсийг харгалзаж болох юм. Тухайлбал,

1. Эсээ бичих сэдвээ тодорхойлно. Сэдвийг оюутнууд сонгох боломжтой, хэд хэдэн хувилбар бүхий байж болно.
2. Сонгосон сэдвээр холбогдох мэдээллийг интернет, ном зохиол судлах зэрэг мэдээллийн эх үүсвэрүүдээс олж авах, материал дээр ажиллах
3. Эсээ бичих төлөвлөгөө боловсруулах
4. Эсээг тодорхой хугацааны дотор бичнэ. Эсээг эргэж засах боломжтойгоор мөр алгассан зайтай бичнэ.
5. Бичсэн эсээгээ хоёр хоёроороо солилцон уншиж харилцан зөвлөнө. (эсээ анхны уншигчийнхаа гар дээр очсон гэсэн үг)

6. Бичигч эсээгээ засварлан хянаж, эсээний төгсгөл, дүгнэлтийг эцсийн байдлаар бичиж дуусгана.
7. Эсээг багш уншин зөвлөгөө өгснөөр эсээ бичлэг үндсэндээ дуусаж “ангийн музей” (эсээгээр ангид гарах үзэсгэлэн)-д түр шилжинэ.

Ингэснээр тэдний бүтээл уншигчдын хэрэглээнд гарч бүтээл нь эргэлтэд орсон гэсэн үг юм. Дараа нь оюутан эсээгээ өөрийн бүтээлийн санд хадгалж хожим ямар нэг бүтээлдээ ашиглах боломжтой болно.

Эсээний мөрөөр ажиллах нь

Эсээг бид дан ганц үнэлгээний хэрэгсэл болговол мөрөөр нь ажиллах олон боломжийг алдаж болох билээ.

Эсээ бичигчийн тухайн сэдвээрх мэдлэгийн хүрээ, нийгэмшил, хүмүүжил төлөвшил, үзэл баримтлал, бүтээлч хандлага, сэтгэлгээний цар, бичиж боловсруулах туршлага зэрэг олон зүйл эсээгээр нь танигдах тул эсээ бол хувь хүнийг судлах хэрэглүүр мөн. Иймд энэ боломжийг багш сурган хүмүүжүүлэгчид, аргазүйч, судлаачид, байгуулага, сургуулийн удирдлагууд сайтар ашиглах хэрэгтэй юм.

Маргаантай болон голч зөв гарцыг олж харах, зөв шийдэлд хүрэх зорилгоор эсээг холбогдох болон судалгааны үнэ цэн, ач холбогдлыг өргөх нэр хүндтэй мэргэжлийн хүмүүсийг оролцуулан бичүүлэх нь өвөрмөц үр дүн, ухаарлыг танд авчрах болно. Дээрх хоёр зорилгоор хэрэглэх эсээг шинжлэх шалгуур асуултыг сайтар боловсруулах хэрэгтэй бөгөөд энд гагцхүү тухайн сэдвээрх үнэ цэнтэй санаа бодлыг цуглуулан анализ хийхэд чиглүүлнэ.

Одоо сургалтын хүрээнд бичүүлсэн эсээний үнэлгээ, дүгнэлтийн талаар зарим зүйлийг тодруулъя.

Эсээ бичигч оюутан, сурагчдад сайн эсээний тухай ойлголт өгөх, эсээний бүтэц, бичлэгийн дэгийг мэдсэнээр эсээ бичих бэлтгэл хангагдана гэдгийг мэдрүүлэх нь эсээний үнэлгээнд сайнаар нөлөөлнө.

Эсээг үнэлэхэд олон талыг харгалзах шаардлагатайг доор авч үзье.

- Эсээнд дэвшүүлсэн бүтээлч сэтгэлгээ
- Гол агуулгаа сэдэв гарчгийн хүрээнд гаргасан эсэх
- Эсээний бүтэц, санаагаа эмх цэгцтэй илэрхийлсэн байдал
- Үндэслэл, дэмжих өгүүлбэрийн хэрэглээ
- Нотолгооныхоо эсрэг үндэслэгээ (бусдын сөрөг бодол санаа)-г оруулсан байдал
- Найруулгын болоод зөв бичгийн дүрмийн алдаагүй, цэвэр бичсэн байдал гэх зэрэг шалгуурыг хүснэгтээр үйлдэн, үнэлж болно.

Сургалтын эсээг багш өөрийн мэргэжлийн хичээлийн бүлэг сэдэв ба, нэгж сэдвийн агуулгаар бичүүлж болно.

Эсээ үнэлэхэд өөрийн ба хөндлөнгийн үнэлгээг тэгш харгалзах, эсээ-бүтээлээр ангийн үзэсгэлэн гаргаж эсээнүүдийг уншигчийн хэрэглээнд оруулж мэдлэг солилцох боломж олговол оюутан, сурагчийн бүтээл эргэлтэд орох ач холбогдолтой юм.

Эсээг эцэст нь оюутан, сурагчийн бүтээлийн санд хадгалуулж бүтээлээр үнэлэх материал болгох боломжтой.

Ашигласан ном зохиол:

1. Оюун, Ц, Монгол хэлний дидактик, түүний аргасудлал, онолын асуудлууд, УБ, 2005
2. Оюун, Ц, Бага ангид монгол хэл заах аргазүй, УБ, 1997
3. МННХ, Ред. Жадамба, Б, Оюун, Ц, нар, Бүтээлч сэтгэлгээ, 8 цуврал ном, УБ, 2000
4. МННХ, БСХ Хөтөлбөр, Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх аргазүй, УБ, 2002
5. Мишель де Монтень, Сонгомол эсээнүүд, УБ, 2004